- 8.1. Хамгаалж байгаа объектод нэвтрэх хүмүүсийн биеийн байцаалтыг шалгаж, зөрчил илэрсэн тохиолдолд Үйлчлүүлэгч болон Хамгаалагч тал болон холбогдох бусад байгууллага албан тушаалтанд мэдэгдэх, хуулийн дагуу шаардлагатай бүх арга хэмжээг авах.
- 8.2. Хамгаалж байгаа эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулахтай холбогдсон саналыг Үйлчлүүлэгчид амаар болон бичгээр тавих.
- 8.3. Хамгаалах эд хөрөнгө, объектын бүрэн бүтэн байдал, лац, ломбо, битүүмжлэлийг шалгаж хүлээн авах, хүлээлгэн өгөх, хэрэв эд хөрөнгө, объектын бүрэн бүтэн байдал алдагдсан, лац ломбо хөдөлсөн байвал энэ тухай Үйлчлүүлэгчид болон өөрийн байгууллагын удирдлагад нэн даруй мэдэгдэх.
- 8.4. Хамгаалж байгаа объектод тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон бусад зүйлийг оруулж гаргахыг Үйлчлүүлэгчийн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлийн хуудсыг үндэслэн гүйцэтгэх бөгөөд энэ тухай тэмдэглэл хөтлөн бүртгэнэ.
- 8.5. Хамгаалалтын ажилтан тухайн объектод мөрдөх журмыг хүндэтгэн ажиллаж, үйлчилгээний байгууллагын ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цаг эхлэхээс 15 минутын өмнө ажлын байранд ирж, хувийн болон албаны бэлтгэлийг хангана.
- 8.6. Хамгаалж буй объектын ажилтнуудтай зөв боловсон харьцана.
- 8.7. Хамгаалалтын албан хаагч нь үүрэг гүйцэтгэж байх хугацаанд болсон үйл явдлыг цаг хугацааны дарааллаар дэлгэрэнгүй илтгэж бичнэ.
- 8.8. Хамгаалж байгаа объектын нийтийн эзэмшлийн гадаад болон дотоод талбайн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг шалгаж ээлж хүлээлцэнэ.
- 8.9. Согтууруулах ундаа хэрэглэсэн гадны хүн болон Үйлчлүүлэгч талын ажилтныг хамгаалалтын объект рүү нэвтрүүлэхийг хориглоно.

ЕС. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 9.1. Энэ гэрээний зорилгын хүрээнд аль нэг талын боломжит хяналтаас гадуур гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал /байгалийн гамшиг, ган, зуд, үер, газар хөдлөлт, үйлдвэрлэлийн осол, дайн, төр засгийн эрх бүхий этгээдийн шийдвэрээр хорио цээр тогтоох, гоц халдварт болон цар тахал гарсан, түүнээс болж хөл хорио тогтоосон,/-ын улмаас энэ гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрэх нөхцөл байдал үүссэнийг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэж ойлгоно.
- 9.2. Гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдлын улмаас гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй талыг дараах тохиолдолд энэ гэрээг зөрчсөн гэж үзэхгүй. Үүнд:
 - 9.2.1. Түүнээс урьдчилан сэргийлэх, санал тавих, өөр хувилбар хайх зэргээр гэрээний нөхцөл болзлыг хангахын тулд боломжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх.
 - 9.2.2. Энэхүү нөхцөл байдал үүссэн талаар нөгөө талдаа аль болох урьдаас урьдчилан мэдэгдсэн байх
- 9.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлын улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон буюу түүнд өртсөн тал нь энэхүү нөхцөл үүссэн тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

АРАВ. ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ

- 10.1. Хамгаалагч тал нь гэрээний үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор олж авсан аливаа баримт материал, бүхий л мэдээлэл (тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой олж авсан мэдээлэл)-ийг бусдад задруулахгүй байх үүрэгтэй (“Нууц Мэдээлэл”). Энэхүү нууцлалыг хуульд заасны дагуу шүүх болон бусад төрийн эрх бүхий байгууллагаас шаардан гаргуулснаас бусад тохиолдолд Үйлчлүүлэгчээс урьдчилсан бичгэн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахгүй. Энэхүү заалт нь Гэрээний үйлчлэх хугацаанд болон Гэрээ дуусгавар болсон хойно ч мөн адил хүчин төгөлдөр байна.

АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

- 11.1. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 11.2. Гэрээг сунгах болон гэрээний хэрэгжилтийн явцад нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээний нэмэлт өөрчлөлтөд Талууд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчинтэй үйлчилнэ. Нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 11.3. Гэрээг аль нэг талын санаачлагаар хугацаанаас өмнө цуцалж болох бөгөөд энэ тохиолдолд гэрээг цуцлах хүсэлтээ гэрээг цуцлах болсон үндэслэлийн хамт нэг сарын өмнө нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ. Гэрээг нэг талын буруутай үйлдлийн улмаас цуцалсан тохиолдолд гэм буруутай тал нь ийнхүү гэрээ цуцалсны улмаас нөгөө талд учирсан хохирлыг нөхөн төлнө.
- 11.4. Гэрээний хугацаа дуусгавар болсон, эсхүл гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан нь гэрээний аль нэг тал нь нөгөө талын өмнө хүлээсэн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус үүргээ биелүүлэх, хохирол, зардлыг хариуцан арилгах үүргээс татгалзах, нөхөн төлөхгүй байх үндэслэл болохгүй.
- 11.5. Энэхүү гэрээтэй холбогдон гарч болох бүхий л санал зөрөлдөөн, маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Харилцан зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХАМГААЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

“АЗИЙН ТОП ЭХЛЭЛ” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

..... П.Эрдэнэбат

Утас: 77137777, 99037451

Имэйл хаяг: aziintop.mn@yahoo.com

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Эрхэт түнш” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

..... Э.Дэлгэрмөрөн

Санхүүгийн менежер

..... Б.Даваадулам

Хуульч

..... Б.Цэнгүнжав

Утас: 77102003

Имэйл хаяг: info@erkhettunsh.com



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ

ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 202307000043

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/101 дугаар тушаалаар “Азийн топ эхлэл” ХХК (Улсын бүртгэлийн дугаар:9011371004, Регистрийн дугаар:5633362, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 3-р хороо Энхтайваны өргөн чөлөө ВИП оффис 501 тоотод байрлах)-ийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар сунгав.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



П.САЙНЗОРИГ

2023 оны 05 дугаар сарын 17 -ны өдөр

СУНГАЛТ: Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын оны дугаар тушаалыг үндэслэн оны дугаар сарын . . . -ны өдрөөс эхлэн жилийн хугацаагаар сунгав.

Тусгай нөхцөл, шаардлага:

**ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА**

СУНГАЛТ: Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын оны дугаар тушаалыг үндэслэн оны дугаар сарын . . . -ны өдрөөс эхлэн жилийн хугацаагаар сунгав.

Тусгай нөхцөл, шаардлага:

**ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА**

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮЛЭЭН
АВСАН ТУХАЙ АКТ

2024.10.24

№ 02

Номгон


Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 06 -ний өдрийн А/439 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны 01 сарын 20 – ний өдрийн А/22 дугаар захирамжаар томилогдсон тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнэх, нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авах комисс, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2 дугаар багийн нутаг дэвсгэрт “Хотгор” нэртэй газарт ашигт малтмалын МУ – 017060, МУ – 017161, МУ -012728, МУ -017057, тусгай зөвшөөрөл бүхий “Сэкер ресурс монголиа” ХХК -ны 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Өлзийт сумын Байн ам 2 дугаар багийн нутаг дэвсгэрт “Ар өнц” нэртэй газарт 10 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийхээр төлөвлөсөн байна.


“Сэкер ресурс монголиа” ХХК нь аймгийн нөхөн сэргээлт хүлээж авах комисст “Ар өнц”, “Сонгинот” нэртэй газаруудад нийт 10.82 га -д хийсэн техникийн нөхөн сэргээлтийг хийж танилцуулав.

Комиссын шийдвэр:

“Сэкер ресурс монголиа” ХХК нь Өлзийт сумын Байн ам 2 дугаар багийн нутаг дэвсгэрт “Ар өнц”, “Сонгинот” нэртэй газаруудад техникийн нөхөн сэргээлт хийсэн байдалтай ажлын хэсэг газар дээр нь үзэж танилцлаа. Тус компаний хийсэн техникийн нөхөн сэргээлт нь “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5917:2008 техникийн ерөнхий шаардлагыг хангаж байна гэж үзэв.

Хавсралтанд заагдсан солбицол бүхий 10.82 га техникийн нөхөн сэргээлт.

Ажлын хэсгийн ахлагч: Байгаль орчны газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч  Д.Содномсамдан

Нарийн бичгийн дарга: Байгаль орчны газрын Газар, газрын хэвлий, Байгаль орчинд
нөлөөлөх байдлын үнэлгээний асуудал хариуцсан газрын ахлах
мэрэгжилтэн  Б.Наранбаатар


Гишүүд:

Байгаль орчны газрын байгаль орчны
хяналтын Улсын байцаагч



Т.Мөнхжаргал

Байгаль орчны газрын усны асуудал
хариуцсан мэргэжилтэн



Б.Зүгдоржав

Өлзийт сумын Байгаль хамгаалагч



Ж.Машбат

Өлзийт сумын иргэний төлөөлөл



Т.Мөнхтоогоо

Хүлээн зөвшөөрсөн:

“Сэкер ресурс монголиа” ХХК – ны гүйцэтгэх захирал



Б.Баттуул


“Хатан шижир” ХХК -ны захирал



П.Ганбилэг



Баянхонгор аймгийн Өлзийт сум Ар өнц



id	grad	min	sec	grad	min	sec
1	45	48	2.4	100	48	17.8
2	45	47	55.1	100	48	24.5
3	45	47	45.8	100	48	28.3
4	45	47	35.9	100	48	32.1
5	45	47	28.4	100	48	34.5
6	45	47	27.5	100	48	32.3
7	45	47	30.9	100	48	29.7
8	45	47	38.3	100	48	28.9
9	45	47	45.1	100	48	26.1
10	45	47	43.9	100	48	21.7
11	45	47	45.7	100	48	19.9
12	45	47	50.5	100	48	23.1
13	45	47	58.2	100	48	16.5

N

Баянхонгор аймгийн Өлзийт сум



2.05 ra

id	grad	min	sec	grad	min	sec
1	45	47	5.7	100	49	33.5
2	45	47	3	100	49	35.2
3	45	46	56.1	100	49	45.2
4	45	46	55.1	100	49	50.3
5	45	46	54.6	100	49	49.9
6	45	46	55.7	100	49	43
7	45	47	2.5	100	49	33.2
8	45	47	5.1	100	49	31.1



УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2024 оны 11 дугаар
сарын 7 -ний өдөр

Дугаар Е-2408-000058

Улаанбаатар хот

Утас: 265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр: Сэкер ресурс монголиа
Улсын бүртгэлийн дугаар:
Регистрийн дугаар: 2862468
Захирал: Баттуул
Холбоо барих дугаар: 11330828
Факс :
И-мэйл хаяг :

2. Төслийн нэр байршил

Төслийн нэр: Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах
Байршил: Баянхонгор, Шинэжинст, 2-р баг, Уртын гол
Харьяалагдах сав газар: Алтайн өвөр говийн сав газар
Хамаарах салбар: Уул уурхай
Төслийн дэлгэрэнгүй: Хотгорын чулуун нүүрсний уурхай

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Сэкер ресурс монголиа

4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчидын тоо	Хоногт ажиллах цаг
15	2 ээлжээр	60	150	12

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	912.0	хоногт 1 хүн	Баянхонгор аймгийн Шинэжинст суманд орших Хотгор чулуун нүүрсний ордыг ил аргаар олборлох төслийн 2024 оны Уулын ажлын төлөвлөгөөний Маягт 12-т үндсэн компаниас 83 хүн ажиллах ба үүний 46 нь уурхайд, 37 хүн нь Улаанбаатар хот дахь оффист ажиллана. Харин туслан гүйцэтгэгч компаниас 866 хүн, ингээд нийт 912 хүн ажиллана.

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ	2000.0	ш	2024 оны Уулын ажлын төлөвлөгөө Маягт 10-т энэ онд "тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 1 га талбайд 2000 ширхэг мод тарихаар төлөвлөсөн байна. Шаардлагатай усыг уурхайн ухлагад орж ирэх шүүрлийн уснаас ашиглана.
Уурхайн өрөмдлөг, тэсэлгээний ажилд шаардлагатай усны хэмжээ	4381.2	100.0 тууш.метр	2024 оны Уулын ажлын төлөвлөгөө Маягт 9-т энэ онд нийт 438.12 мян.тууш.м өрөмдлөгийн ажил хийгдэнэ. Өрөмдлөгт шаардлагатай усыг уурхайн ухлагад орж ирэх шүүрлийн уснаас ашиглана.
Уурхайд шүүрлээр орж ирэх усны хэмжээ /Баруун хэсэг/	627.0	м3	Баянхонгор аймгийн Шинэжинэст сумын нутаг дахь Хотгорын нүүрсний уурхайн ордын гидрогеологийн судалгааны тайлангийн ашиглалтын 1 дэх жилд уурхайд шүүрлээр орж ирэх усны хэмжээг үндэслэв. /Уурхай нь 2024 онд өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа эхлээгүй байгаа тухай орон нутгаас тодорхойлсон албан бичигтэй/

6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

Эх үүсвэр	Зориулалт	Усны нөөц (л)	Усны нөөц (м3)	Тайлбар
Гүний худаг	Унд ахуй	36.5	3153.6	Унд ахуйн усыг гүний худгаас ашиглана
Шүүрлийн ус	Техникийн хэрэгцээнд	45.0	3888.0	Шүүрлийн уснаас Тоосжилт бууруулах, ногоон байгууламжийн усыг шавхан зайлуулах зорилгоор ашиглана.

7. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ :	Баялаг эко
Холбоо барих :	80828085
Нэмэлт мэдээлэл:	мэргэжилтэн

8. Усны барилга байгууламжууд

Барилга байгууламж	Хүчин чадал (м3)	Хэмжээ хийц
Гүний худаг	3153.6	Инженерийн хийцлэлтэй цооног

9. Дамжуулах байгууламж

Хаанаас (эхлэх цэг)	Хаана хүртэл (төгсгөлийн цэг)	Шугамын голч, мм	Дамжуулах шугамын урт, м
---------------------	-------------------------------	------------------	--------------------------

10. Онцгой нөхцөл

- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглоно;
- Голын хамгаалалтын бүсэд хөрс хуулалт, олборлолт явуулахыг хориглоно;
- Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах арга хэмжээ авах, хөв цөөрөм байгуулах, татмын ойжуулалт хийх г.м;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож төлбөр төлөх;
-

11. Усны зарцуулалт

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, м3 (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ, м3	Хөнгөлөх усны хэмжээ м3	Төлбөр тооцох усны хэмжээ м3
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	912.0	хоногт 1 хүн	0.15	60.0	Хоног	8,208.00	0.00	8,208.00
"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ	2000.0	ш	0.045	12.0	Удаа	1,080.00	1,080.00	0.00
Уурхайн өрөмдлөг, тэсэлгээний ажилд шаардлагатай усны хэмжээ	4381.2	100.0 түүш.метр	10.0	1.0	Удаа	43,812.00	43,812.00	0.00
Уурхайд шүүрлээр орж ирэх усны хэмжээ /Баруун хэсэг/	627.0	м3	1.0	60.0	Хоног	37,620.00	0.00	37,620.00
Нийт						90,720.00	44,892.00	45,828.00

12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

Ажлын нэр	Төлбөр тооцох усны хэмжээ, м3	Усны ангилал	Хөнгөлөх хувь хэмжээ, %	1 м3 усны үнэ	Усны нөөц ашигласны төлбөр, ₮	Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮	Төлбөл зохих дүн, ₮
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	8208.00	Газрын доорх ус	0.0	99.74	818,686.44	0.0	818,686.44
"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ	0.00	Газрын доорх ус	0.0	88.66	0.00	0.0	0.00
Уурхайн өрөмдлөг, тэсэлгээний ажилд шаардлагатай усны хэмжээ	0.00	Газрын доорх ус	0.0	2172.17	0.00	0.0	0.00
Уурхайд шүүрлээр орж ирэх усны хэмжээ /Баруун хэсэг/	37620.00	Газрын доорх ус	0.0	797.94	30,018,502.80	0.0	30,018,502.80
Нийт	45,828.00				30,837,189.24		30,837,189.24

13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

- Уурхайн шүүрлийн усыг ногоон байгууламжийн усалгаа болон зам талбайн тоосжилт дарахад ашиглах;

14. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Алтайн өвөр говийн сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолой бүрд баталгаажуулсан онлайн тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх.
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах.
- Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2024 оны 12 дугаар сарын 20-ны дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах;

Боловсруулсан:

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТЭС

Боловсруулсан огноо:

Мөнхцэцэг

2024.11.07



Байгууллагын нэр: **Усны газар**
Газар хэлтэс: **Усны газар**
Албан тушаал: **Даргын албыг түр орлон гүйцэтгэгч**
Овог нэр: **Зэнэмядар Батбаяр**
Зурсан огноо: **2024.11.08 20:23:23**



АЛТАЙН ӨВӨР ГОВИЙН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/22

Даланзадгад сум

Зөвшөөрөл олгох тухай

Усны тухай хуулийн 28.6 дахь заалт, 29 дүгээр зүйл, 17.1.10 дахь заалт, 30.1 дэх хэсэг, 30.3 дахь хэсэг, 7.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2024 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн Е-2410-000097 дугаартай ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар олборлох төслийн 2024 оны ус ашиглах зөвшөөрлийг уурхайд шүүрлээр орж ирэх усны хэмжээ /баруун хэсэг/ 37,620.00 м³, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ 8,208.0 м³, уурхайн өрөмдлөг, тэсэлгээний ажилд шаардлагатай усны хэмжээ 43,812.00м³, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад шаардлагатай усны хэмжээ 1,080.00м³ усыг тус тус байгалийн нөөцөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Ус ашиглагч нь ус ашиглах зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж 200,000 (Хоёр зуун мянган) төгрөг, ус ашиглах гэрээ байгуулах тэмдэгтийн хураамж 100,000 (Нэг зуун мянган) төгрөгийг тус тус Баянхонгор аймгийн төрийн сангийн дансанд тушаах, ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавих шаардлагыг хангаж ажиллаж, усны тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2024 оны 12 дугаар сарын 20-ний дотор сав газрын захиргаанд ирүүлж ажиллахыг уурхайн гүйцэтгэх захирал (Б. Баттуул) -д даалгасугай.

3. Усны ашиглах боломжит нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж, ус ашиглагчтай гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг дараа оны 01 дүгээр сард багтаан дүгнэж байхыг Газрын доорх усны нөөц, ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (С.Диймаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б. ПҮРЭВТУЛГА

БАТЛАВ.

АЛТАЙН ӨВӨР ГОВИЙН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА



Б. ПҮРЭВТУЛГА

БАТЛАВ.

“СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б. БАТТУУЛ

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 11 сарын 29-ны өдөр

Дугаар 24/12

Даланзадгад хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29- дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Усны газрын 2024 оны 11 дугаар сарын 07-ны өдрийн E-2408-000058 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Алтайн өвөр говийн сав газрын захиргааны 2024 оны 11 дугаар сарын 29-ний өдрийн А/22 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Нэг талаас: Ус ашиглуулагчийг төлөөлж “АЛТАЙН ӨВӨР ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА”-ны Газрын доорх усны нөөц, ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн С.Диймаа,

Нөгөө талаас: Ус ашиглагчийг төлөөлж, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма ганди гудамж, Форум төвийн 5-р давхар 9019097451 тоот улсын бүртгэлийн дугаар, 2862468 регистрийн дугаартай, delgerjargal@srmongolia.mn, , утас: 11330828 , 99918876 “ Сэкер ресорсус монголиа” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн Ч. Дэлгэржаргал нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2024 оны 12 дугаар сарын 31-ыг дуустал энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт:

- Уурхайд шүүрлээр орж ирэх усны хэмжээ / Баруун хэсэг/
- Уурхайн өрөмдлөг, тэсэлгээний ажилд шаардлагатай усны хэмжээ
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ
- Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл , үйлчилгээнд ашиглах

2.2. Ашиглах усны хэмжээ:

- 2.2.1 Уурхайн шүүрлээр орж ирэх усны хэмжээ /Баруун хэсэг/ -37,620.00м³
- 2.2.2 Уурхайн өрөмдлөг, тэсэлгээний ажилд шаардлагатай усны хэмжээ-43,8142.00м³
- 2.2.3 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ-1,080.00м³
- 2.2.4 Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах -8,208.00 м³

2.3. Усны чанар, найрлага: Унд ахуйд ашиглах уснаас улирал тутам дээж авч шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг тухай бүр сав газрын захиргаанд ирүүлэх

2.4. Усны эх үүсвэр: Усны газрын 2024 оны 67 дугаартай усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд “ Сэкер Ресорсус Монголий” ХХК-хэрэгжүүлэх Хотгор чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглагдах төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах 6,831.65м³/хон усны хэрэгцээг өөрийн эзэмшлийн

талбайнд гаргуулсан 36.5л/сек (3,153,6м³/хон) нийлбэр ундаргатай 8 гүний худаг, ил уурхайн 3 карьерийн нийлбэр 4,322.63м³/хон шүүрлийн уснаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.

Гүний худгийн мэдээлэл, координат:

№	Худаг	Утраг	Өргөрөг	Ундарга (л/с)
1	CSB01	514135.25	4940105	1.7
2	TB01	514407.36	49356219	10.0
3	TB02	515977.26	4935585	7.5
4	TB03	518964.38	4935360	0.8
5	TB04	521231.72	4935486	1.0
6	TB05	517794.03	4937534	1.5
7	TB06	517048.27	4936291	5.0
8	TB07	517268.16	4935385	9.0

2.5. Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага: Хаягдал бохир усыг цэвэрлэх байгууламжийн шугам болон хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ MNS:6561:2015, MNS:4943:2015 стандартуудыг мөрдлөг болгох. Нүхэн жорлон, угаадасны нүх техникийн шаардлага MNS:5924:2015 стандартыг мөрдөх

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодис, шинжилгээний дүн: Ахуйн хэрэгцээнд ашигласан уснаас гарах хаягдал усны хэмжээ, чанар найрлага, бохирдуулагч бодисын хэмжээ зэрэгт улирал тутамд шинжилгээг Ус цаг уур орчны шинжилгээний төвөөр хийлгэн хариу болон дүгнэлтийг тухай бүр сав газрын захиргаанд ирүүлэх.

- Жинлэгдэх бодис /кг/
- Органик бодис /кг/
- Эрдэс бодис /кг/
- Хүнд метал /кг/
- Аюултай бохирдуулах бодис /гр/

2.7. Хаягдал ус хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга, түвшин
Байхгүй

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдол, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

Д/д	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Ил уурхайн ашиглалтаас газрын доорх ус хомсдох	Уурхай орчмын уст цэгийг хамгаалалтад авах, тохижуулах	-	7,000.000	Жилийн эцэст
2		“Усны зохистой хэрэглээ” сэдэвт сургалт-Шинэ ажилтны сургалтаар мэдээлэл хүргэх	-	Дотоод зардал	Шинэ ажилтан ирэх бүрд

3	Булгийн эхийн хог хаягдлыг хамгаалах цэвэрлэх	Нөлөөллийн бүсэд ойр орших булаг	-	100,000	3 болон 8 дугаар саруудад
4	Сумын хэмжээнд ашиглагдаж байгаа ундны эх үүсвэрүүдээс дээж авч шинжилгээнд хамруулан орон нутгийн иргэдэд танилцуулах	Сумын зүүн хойд худаг задгай булаг	-	ОХШХ	6 болон 11 дүгээр саруудад

2.8.1 Дэлхийн усны өдөр болон байгаль хамгаалах өдрүүдийг сав газрын захиргаатай хамтран зохион байгуулах

2.8.2 Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэх.

2.9. Усны тоолуур:

Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу худаг болон шүүрлийн усыг ашиглах шугам хоолой бүрд тоолуур суурилуулж баталгаажуулж ажиллах.

2.10. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцоход:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан “нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм” болон компанийн 2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглах усны зарцуулалтыг тооцоход:

2.11. Усны зарцуулалт

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ м ³ (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ м ³	Хөнгөлөх усны хэмжээ м ³	Төлбөр тооцох усны хэмжээ
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	912.0	Хоногт 1 хүн	0.15	60.0	хоног	8,208.00	0.00	8,208.00
“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ	2000.0	ш	0.045	12.0	удаа	1,080.00	1,080.00	0.00
Уурхайн өрөмдлөг,	4381.2	100.0 тууш.метр	10.0	1.0	удаа	43,812.00	43,812.00	0.00

тэсэлгээний ажилд шаардлагатай усны хэмжээ								
Уурхайд шүүрлээр орж ирэх усны хэмжээ /Баруун хэсэг/	627.0	м ³	1.0	60.0	хоног	37,620.00	0.00	37,620.00
Нийт						90,720.00	44,892.00	45,828.00

2.12. Хууль тогтоомжийн дагуу ногдуулах усны нөөц ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

“Усны экологи эдийн засгийн үнэлгээг батлах тухай” Засгийн газрын 2011 оны 302 тоот тогтоолоор Алтайн Өвөр говийн сав газарт тогтоосон усны экологи эдийн засгийн суурь үнэлгээгээр, 2013 оны 326, 327-р тогтоолоор ашиглалтын зориулалтын итгэлцүүр, хувь хэмжээгээр усны нөөц ашигласны төлбөрийг тогтоож, тогтоосон хэмжээгээр Төсвийн тухай хуулийн 23.8.9-д заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

2.12.1. Ашиг олох зориулалтаар ахуй үйлдвэрлэл, үйлчилгээнд газар доорх усны нөөц ашигласны төлбөр

$$\underline{1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 4.433.0 \text{ төг} \times 0.15 \times 0.15 = 99.74 \text{ төг/м}^3$$

- 4,433.0төг/м³ – Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Алтайн өвөр говийн сав газарт тогтоосон газрын доорх ус ус ашигласан нөхцөлд экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;
- 15% – Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 10-д заасан газрын доорх усыг ашиг олох зориулалтаар ашигласан усны нөөц ашигласны төлбөрийн хувь
- 0.15-Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолд заасан Алтайн өвөр говийн сав газарт газрын доорх усны ашиг олох зориулалтаар ашигласны тооцох итгэлцүүр

$$8208.00\text{м}^3/\text{жил} \times 99.74\text{төг/м}^3 = 818,686.44 \text{ төг}$$

Уурхайд шүүрлээр орж ирэх усны төлбөр /Баруун хэсэг/

$$\underline{1\text{м}^3 \text{ газрын доорх усны үнэ: } 4.433.0 \text{ төг} \times 0.15 \times 1.2 = 797.94 \text{ төг/м}^3$$

- 4,433.0төг/м³ – Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Алтайн өвөр говийн сав газарт тогтоосон газрын доорх ус ус ашигласан нөхцөлд экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;
- 15% – Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 10-д заасан газрын доорх усыг ашиг олох зориулалтаар ашигласан усны нөөц ашигласны төлбөрийн хувь
- 1.2-Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолд заасан Алтайн өвөр говийн сав газарт газрын доорх усны ашиг олох зориулалтаар ашигласны тооцох итгэлцүүр

$$37620.00\text{м}^3/\text{жил} \times 797.94\text{төг/м}^3 = 30,018,502.80 \text{ төг}$$

Нийт төлбөр: 818,686.44+30,018,502.80= 30, 837, 189.24 төг

/Гучин сая найман зуун гучин долоон мянга нэг зуун наян есөн төгрөг /

- 2.13. Дээрх усны нөөц ашигласан төлбөрийг Баянхонгор аймгийн төсөвт “Усны тухай” хуулийн 30.1.4-д заасны дагуу баталгаажуулсан тоолуурын заалтаар тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ба тоолуургүй ашигласан хугацаанд ногдуулах төлбөрийг дүгнэлтээр тооцно.
- 2.14. Усны нөөц ашигласны төлбөр, болон шавхан зайлуулах газрын доорх ус ашигласны төлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор гүйцэт төлж барагдуулах;
- 2.15. Усны хяналтын тоолуурын ажиллагаа техникийн шалтгаанаар зогссон бол холбогдох хүмүүсийг байлцуулан зураг болон акт үйлдэн Сав газарт мэдэгдэх;
- 2.16. Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө унд ахуйн болон бохир ус зайлуулах ажлыг стандартын дагуу хангаж ажиллах;
- 2.17. Шавхан зайлуулах газрын доорх ус ашигласны төлбөрийн хэмжээг тоолуурын заалтаар төлж барагдуулна. Тоолуур суурилуулаагүй болон ажиллаагүй тохиолдолд ус ашиглуулах дүгнэлтэд заасны дагуу төлбөрийн хэмжээг төлж барагдуулна.

Гурав. Талуудын эрх, үүрэг

- 3.1 Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1, 10.1.3-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөвт. Бусад

- 4.1 Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно;
- 4.2 Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна;
- 4.3 Гэрээний биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор ус ашиглалтын тайланг хүлээн авч, гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ;
- 4.4 Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ;
- 4.5 Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцална.
 - 4.5.1 Монгол улсын холбогдох хууль тогтоомж, энэхүү гэрээнд үүргээ биелүүлээгүй тохиолдолд Ус ашиглуулагчийн шийдвэрээр;
 - 4.5.2 Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
 - 4.5.3 Байгаль орчныг хамгаалах тухай болон усны тухай хууль тогтоомж зөрчсөн;
 - 4.5.4 Ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд нь төлөөгүй;
 - 4.5.5 Усны эх үүсвэрийг бохирдуулсан;
 - 4.5.6 Усны тоолуур болон тохиргооны тоног төхөөрөмж суурилуулаагүй буюу ашигласан усны тооцоог хуурамчаар тооцсон;
 - 4.5.7. Аль нэг тал татан буугдсан;
- 4.6 Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ;
- 4.7 Ус бохирдуулсны төлбөрийг ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7.1, 7.2 үндэслэн /Засгийн газрын тогтоол гарснаар хүчин төгөлдөр болно/ барагдуулна;

- 4.8 Усны тоолуур эвдэрсэн тохиолдолд Сав газрын захиргаанд яаралтай мэдэгдэж, усны тоолуурыг шугамаас салгах, баталгаажуулсны дараа буцааж тавихад байлцах, тоолуурын засвар, суурилуулалтыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар хийлгэх;
- 4.9 Газрын доорх усны цооног, ашиглалтын худаг, шүүрлийн уст цэгүүдэд усны тоолуур суурилуулаагүй тохиолдолд гэрээнд заасан усны хэмжээгээр төлбөрийг төлж барагдуулах;
- 4.10 Ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэглээнээс гарсан усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхэд “Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943-2015” стандартад нийцүүлж Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газар, Сав газрын захиргаанд ирүүлж байх;
- 4.11 Усны нөөц бохирдох, хомстохоос сэргийлэх арга хэмжээний хүрээнд олон нийтийг хамарсан сургалт семинар зохион байгуулах, баянбүрдийг сэргээх, хөв цөөрөм байгуулах, булаг шандын эхийг хашиж хамгаалах, инженерийн хийцтэй худаг уст цэг гаргах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхдээ манай байгууллагатай хамтран ажиллах, тайлан мэдээг 06 дугаар сарын 01, 12 дугаар сарын 01-ний дотор тус тус ирүүлж байх.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ,
АШИГЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

С. Диймаа С. ДИЙМАА

Хаяг: Өмнөговь аймаг, Даланзадгад сум,
3-р баг, Төрийн банкны байр, 4 давхар.

Харилцах утас: 70534080

Факс: 70534081

Ус ашиглагчийг төлөөлж:

“СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА” –ХХК-НИЙ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН



Ч. ДЭЛГЭРЖАРГАЛ

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р
хороо, Махатма ганди гудамж Форум төвийн 5-р
давхарт

Харилцах утас: 99918876

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хавсралт

ХОГ ХАЯГДАЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024.03.22

№	Төлөвлөлт	Хэрэгжилт
1	Уст цэгийн нэр	Баянхонгор аймгийн Шинэжинст сумын "Задгай" булаг
2	Цэвэрлэгээ зохион байгуулахад хамрагдсан ажилчдын тоо /зураг/ Машин техник хэрэгслийн тоо	"Сэкер Ресорсус Монголиа" ХХК Уурхайн 12 ажилтан Портер-1ш
3	Цэвэрлэсэн талбай хэмжээ, га	0,8 га
4	Хог хаягдлын ангилал /ахуйн, хуванцар сав, шил лааз/ хэмжээ, тн	Хуванцар сав, гялгар уут, шил лааз-8 уут
5	Нэмэлт мэдээлэл	Булгийн эхээс 500м радиуст хуванцар, гялгар уут, шил, лааз түүсэн.

Тайлан гаргасан:



Эрхэт түнш ХХК-ийн ХАБЭАБО-ны менежер

Хянасан:

Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн ХАБЭАБО-ны менежер

Танилцсан:

Шинэжинст сумын БОХУБайцаагч

 /Х. Ууганбаатар/
 /Э. Батцэрэн/
 /Ш. Бямбацогоо/


ХОГ ХАЯГДАЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024.03.24

№	ТӨЛӨВЛӨЛТ	ХЭРЭГЖИЛТ
1	Кэмгийн гадна талбай	Баянхонгор аймаг Шинэжинст сумын нутаг
2	Цэвэрлэгээ зохион байгуулахад хамрагдсан ажилчдын тоо / зураг / Машин технил хэрэгслийн тоо	“Сэкер Ресорсус Монголиа”ХХК, “Эрхэс Түнш”ХХК, “Өрнөх үндэс”ХХК Ажилчдын тоо 23 Нилух ачааны 1
3	Цэвэрлэсэн талбай хэмжээ, га	Кэмпээс 3 км зайнд ил хогийг цэвэрлэсэн
4	Хог хаягдалын ангилал / ахуйн хуванцар сав, шил лааз / хэмжээ, тн	Хуванцар сав, гялгар уут, 00-ын цаас, хатуу хог, малын сэг яс,
5	Нэмэлт мэдээлэл	Кэмпээс 10км зайнд тарж бүх ил хогийг цэвэрлэсэн

ТАЙЛАН ГАРГАСАН:

“ӨРНӨХ ҮНДЭС” ХХК-ийн ХАБЭАБО-ны мэргэжилтэн
/ Ц. Дэлгэрмөрөн /

ХЯНАСАН:

“ЭРХЭТ ТҮНШ” ХХК-ийн ХАБЭАБО-ны менежер
/ Х. Ууганбаатар /

ТАНИЛЦСАН:

ШИНЭЖИНСТ сумын БОХУ БАЙЦААГЧ
/ Ш. Бямбацогоо /



Худалдаа Хөгжлийн Банк

Огноо: 2025.01.23 18:02:58

Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: 214999781

Системийн огноо: 2025.01.10

Нэр: СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА ХХК

Илгээгч	Дансны дугаар: 404118095	Нэр СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА ХХК	Дүн 43,088.76 MNT	Ханш 1.00
/ дөчин гурван мянга наян найман төгрөг далан зургаан мөнгө /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 04	Банкны нэр Худалдаа Хөгжлийн Банк	43,088.76 MNT	1.00
	Дансны дугаар	Нэр		

Гүйлгээний утга:

ЕВ -3241201571251-Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр-Б**Танд баярлалаа****Гүйлгээний баримтыг баталгаажуулсан**

Салбар, тооцооны төв:

Гарын үсэг:

Тамга:

Огноо: _____ Он ____ Сар ____ Өдөр

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын /Journal No: 37333505

Системийн огноо/System Date: 2025-01-23 17:35:02

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5170019511	СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА	24,877.86 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No 050000	Банкны нэр/Bank Name ХААН БАНК		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name	24,877.86 MNT	1.00
	5176120446	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР		

Гүйлгээний утга/Transaction description:

1250105055578; 2862468; 99476131

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Cap/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын /Journal No: 37285950

Системийн огноо/System Date: 2025-01-23 17:34:24

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5170019511	СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА	43,088.76 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No 050000	Банкны нэр/Bank Name ХААН БАНК	43,088.76 MNT	1.00
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name		
	5176120446	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР		

Гүйлгээний утга/Transaction description:

3241201571251; 2862468; 99476131

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Cap/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

Гэрээний товч утга: Энэхүү Гэрээгээр Гүйцэтгэгч тал нь зориулалтын шатаах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг Гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх, устгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Нийт үнэ: Аюултай хог хаягдлын хэмжээнээс хамааран устгал өгөх бүрд тооцно.
 Устгал өгөхөөс өмнө устгалын урьдчилгаа төлбөр 2,500,000 (Хоёр сая таван зуун мянга) төгрөг (Энэ дүнд НӨАТ болон аливаа татвар хураамж багтаагүй болно)

Гэрээний хугацаа: 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 1 (нэг) жил

Гэрээний байгуулах хүсэлтийг хариуцсан албан тушаалын тодорхойлолт, компанийн ажлын төлөвлөгөөнд заасны дагуу ирүүлсэн, цаашид гэрээний хэрэгжилтийг хариуцаж ажиллах амжилтан:


Лабораторийн мэргэжилтэн  С.Одбаяр

Гэрээний төслийг бэлтгэсэн: Гүйцэтгэгчээс ирүүлсэн гэрээний төсөлд санал оруулж бэлтгэв.

Туслах хуульч  О.Түвшинсайхан

The undersigned confirms that the draft contract has been reviewed and approved the final version of the contract.
 (Contract No. /2024)

Дор гарын үсэг зурсан нь 2024 оны дугаар Гэрээний төслийг хянаж, гэрээний эцсийн хувилбарыг зөвшөөрч байна.

Contract title/Гэрээний нэр:	ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ (Гүйцэтгэгч: “Элемент” ХХК)					
	Renewed by /Хянасан:	Divisions/ Газар, хэлтэс	Name/Овог, нэр	Comment/Санал	Date/ Огноо	Sign/Гарын үсэг
Saker Resource Mongolia LLC	Ерөнхий захирал	М.ЧОЙДОРЖ				
Saker Resource Mongolia LLC	Үйл ажиллагаа хариуцсан захирал	Н.ГАНСҮХ		2024/02/16		
Saker Resource Mongolia LLC	Санхүү, Хөрөнгө оруулалт, Борлуулалтын хэлтсийн ерөнхий менежер	Б.МӨРӨНГУА				

N.B.: If the person is on the site or on a business trip then confirmation should be obtained via e-mail and should be attached to the confirmation page. In the case of absence of signatory due to illness or other private reasons the acting officer shall sign on the confirmation page. After all approvals, contract could be approved by General Director.

Анхаарах нь: Хэрэв тухайн хүн орон нутаг дахь ажлын байранд, эсхүл томилолтой байгаа бол зөвшөөрлийг цахим шуудангаар авч хяналтын хуудаст хавсаргана. Гарын үсэг зурагч нь өвчний, эсхүл хувийн бусад шалтгаанаар эзгүй байгаа тохиолдолд үүргийг орлон гүйцэтгэж буй ажилтан хяналтын хуудаст гарын үсэг зурна. Бүх зөвшөөрлийг авсны дараа Ерөнхий захирлаар гарын үсэг зуруулна.

БАТЛАВ:
"ЭЛЕМЕНТ" ХХК-ИЙН

Б.ЭНХБАДРАЛ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
2100061 + СБТ1561

БАТЛАВ:
"СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА" ХХК-
ИЙН

М.ЧОЙДОРЖ
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ ХБ-24/026.

2024 оны 2-р сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ,
УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ (цаашид "Гэрээ" гэх)-г

Нэг талаас "Элемент" ХХК /рд:2100061/ (цаашид "Гүйцэтгэгч" гэх) төлөөлж,
Химийн мэргэжилтэн албан тушаалтай Э.Халиун,
Нөгөө талаас "Сэкер Ресорсус Монголиа" /рд:2862468/ (цаашид "Захиалагч")
ХХК-ийг төлөөлж Лабораторийн мэргэжилтэн албан тушаалтай
С.Одбаяр

нар (цаашид хамтад нь "Талууд", тус тусад нь "Тал" гэх) харилцан тохиролцож, Монгол
Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын
тухай хууль, Байгаль орчны тухай хууль Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал
жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт
болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох
хууль тогтоомжийг үндэслэн энэхүү Гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь зориулалтын шатаах зууханд химийн
бодисын аюултай хог хаягдлыг Гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх, устгах,
Захиалагч тал нь Гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага
хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад
оршино.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Захиалагч дараах эрхтэй:

- 2.1.1. Гүйцэтгэгч талаас Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй;
- 2.1.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа
холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн
хэрэгслээр тээвэрлэхийг шаардах;
- 2.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж,
булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.

2.2. Захиалагч дараах үүрэгтэй:

- 2.2.1. Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2
дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь
"Аюултай хог хаягдал" гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг,
тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр,
хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх;

- 2.2.2. Үүссэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах;
- 2.2.3. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх. Мөн химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл дагалдан өгч явуулах;
- 2.2.4. Аюултай хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах;
- 2.2.5. Хадгалсан хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө бодит хэмжээг бодитоор зөв хэмжих;
- 2.2.6. Аюултай хог хаягдал тээвэрлэж, устгасан хөлсийг Гэрээнд заасан хугацаанд төлөх;
- 2.2.7. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн Гүйцэтгэгчийн ажилтан бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохирлыг Захиалагч бүрэн хариуцлага хүлээх;
- 2.2.8. Аюултай хог хаягдлаа ачиж тээвэрлэх, захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтныг байгууллага дээрээ байлгаж, хог ачилтад хяналт тавих тус тус үүрэгтэй.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Гүйцэтгэгч дараах эрхтэй:
 - 3.1.1. Захиалагч талаас Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,
 - 3.1.2. Аюултай хог хаягдал тээвэрлэсний хөлсийг Гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй;
 - 3.1.3. Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой, хаяг шошготой, аюултай тэмдэглэгээтэй байхыг шаардах хаяггүй бол тээвэрлэхгүй байх эрхтэй;
 - 3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг шаардах эсвэл дагалдах бичиггүй бол хог хаягдлыг тээвэрлэхгүй байх эрхтэй.
- 3.2. Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:
 - 3.2.1. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, тээврийн хэрэгслийг ажилд бэлэн байлгаж, Захиалагч талын хог хаягдлыг Гэрээнд заасан хуваарийн дагуу хугацаанд зориулалтын тээврийн хэрэгслээр саадгүй тээвэрлэх;
 - 3.2.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж, бүрэн хүлээн авах, түүнээс үүдэх аливаа эрсдэл хариуцлагыг бүрэн хариуцах;
 - 3.2.3. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн Захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохирлыг Гүйцэтгэгч бүрэн хариуцах;
 - 3.2.4. Аюултай хог хаягдалтай холбоотой зөрчил илэрсэн болон засаж сайжруулах шаардлагатай санал байгаа тохиолдолд мэдэгдэх;
 - 3.2.5. Аюултай хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аюулгүй болгон устгах;
 - 3.2.6. Устгал хийгдсэний дараа устгалын акт гаргах тус тус үүрэгтэй;
 - 3.2.7. Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд харилцан тохиролцож, Гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол Гэрээнд нэмэлт тодотгол оруулж болно.

ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1. Үйлчилгээний төлбөр нь тухайн устгах аргачлалын дагуу устгалын үед аюултай хог хаягдлын хэмжээнээс хамааран, устгал өгөх бүрд тооцож нэхэмжилнэ. Аюултай хог хаягдлын устгалын төлбөрийг хавсралт №1-т тусгав.
- 4.2. Захиалагч аюултай хог хаягдлын устгал өгөхөөс өмнө устгалын урьдчилгаа төлбөр **2,500,000 /Хоёр сая таван зуун мянга/** төгрөг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн түүний дансанд шилжүүлнэ. Урьдчилгаа төлбөр нь нийт устгалын зардлаас хасагдаж тооцогдоно.
- 4.3. Аюултай хог хаягдлыг Гүйцэтгэгч ачилт тээвэрлэлт хийх үед болон усгалын төвд хүлээн аван нарийн хэмжилт хийх үед Гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан тохиолдолд гүйцэтгэлээр Захиалагч талаас нэхэмжилнэ.
- 4.4. Гэрээний төлбөрийг ажил гүйцэтгэж дууссаны дараа Гэрээнд заасан журмаар устгалын акт үйлдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор “Элемент” ХХК-ийн 1715164140 /Голомт банк/ тоот дансанд төлнө.
- 4.5. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаандаа төлбөр төлөгдөөгүй тохиолдолд боломжит хугацааг мэдэгдэж, онцгой объектыг харгалзан үзэж, энэхүү хугацаанд төлбөр төлөх хүртэл үйлчилгээг тасалдуулахгүй хүргэнэ.
- 4.6. Төлбөр тооцоог байгууллагын данснаас бусад хувь хүний дансанд шилжүүлснээс үүдэх хохирлыг Гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.
- 4.7. Энэхүү Гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж, Гэрээг 1 жил буюу 2024 оны 2 дүгээр сарын 15 -ны өдрөөс 2025 оны 2-р сарын 15-ны өдөр хүртэлх хугацаагаар байгуулав.

ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 5.1 Энэхүү Гэрээний 4.4-т заасан хугацаанд Захиалагч тал үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар алданги төлнө.
- 5.2 Энэхүү Гэрээний 4.7-д заасан хугацаанд Гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувиар алданги төлнө.
- 5.3 Үйл ажиллагаандаа дагаж мөрдөх дүрэм журмыг мөрдөөгүйгээс Гэрээнд оролцогч талуудад гэм хор учирсан бол буруутай тал нь хариуцлагыг бүрэн хүлээнэ.

ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 6.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.
- 6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэнэ. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно.
- 6.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тухай тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргуулж авна. Энэ тохиолдолд Талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

- 6.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Гэрээний үүргээ биелүүлээгүй,эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тал нь энэ тухайгаа нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 7.1. Талууд энэ Гэрээг биелүүлэх явцад иргэний болон эрх зүйн маргаанд хамаарагдах асуудлаар бие биедээ өгсөн зөвлөмжийг анхааралдаа авч ажиллана.
- 7.2. Энэхүү Гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл Захиалагчийн оршин байгаа газрын харьяаллаар Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ

- 8.1. Талууд энэхүү Гэрээг байгуулсантай холбоотой болон Гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, ажилтан ажиллагсад, харилцагч, үйлчлүүлэгчийн байгууллагын болон ажилтны хувийн нууцад хамааралтай (техник, санхүү, бизнес, хувь хүний эрүүл мэндийн мэдээллийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн, аман болон бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 8.2. Энэхүү Гэрээний 8.1-д заасан нөхцөлийг зөрчсөн тал үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа үр дагавар, хохирлыг хуулийн дагуу арилгах үүрэг хүлээнэ.

ЕС. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

